

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	НТАГ-ын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegva@audit.gov.mn Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар.....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5.1 Төлбөрийн акт	25
5.2 Албан шаардлага	25
5.3 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХЭ	Аудитын хуулийн этгээд
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/182
танай _____-ны № _____-т

ЭНЭРЭЛ ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ А.СУВДАА ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Энэрэл эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Энэрэл эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

- Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт, нотлох баримтгүйгээр олгосон;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн;
- Хөрөнгийн тооллого хийгээгүй, шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй;
- Санхүүгийн тайлан, төсөв гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнаж, санхүүгийн тайланг бүрэн бусаар хуулийн хугацааг 18 хоногоор хоцроосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 8.9.1, 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 8.4, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 20.2.9 санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад эмнэлгийн удирдлага болон нягтлан бодох бүртгэлийн ажилчид 2024 оны сүүлийн улиралд

солигдсон нь туршлагатай боловсон хүчин, хүний нөөцийн дутмаг байдал үүссэн байна.

Энэ нь байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг бүрэн хангаагүйтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Нийслэлийн Эрүүл мэндийн газраас эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах эрхийг Энэрэл эмнэлэгт олгосон байна.

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд тусгасан орон нутгийн чиг үүргийн хүрээнд 2024 оноос Энэрэл эмнэлгийн тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс нэмэлт санхүүжилтээр олгож байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 стратеги зорилгын, 15 зорилтын хүрээнд 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 98.4 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>757,792,038.53</u>	<u>893,705,387.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	373,027.53	27,074,550.90
312	Банканд байгаа бэлэн мөнгө	373,027.53	27,074,550.90
31211	Төрийн сангийн харилцах	-	23,521,421.98
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	373,027.53	3,553,128.92
33	АВЛАГА	270,286,100.00	376,761,046.64
33100	Ажилчидтай холбоотой авлага	-	458,952.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	270,286,100.00	376,302,094.64
34	УРЬДЧИЛГАА	1,801,370.38	1,666,666.67
34600	Урьдчилж гарсан зардал	1,801,370.38	1,666,666.67
35	БАРАА МАТЕРИАЛ	485,331,540.62	488,203,123.46
351	Түүхий эд материал	326,707,660.21	298,911,661.12
35130	Эм боох материал	326,707,660.21	298,911,661.12
354	Хангамжийн материал	158,623,880.41	189,291,462.34
35410	Бичиг хэргийн материал	2,494,750.00	2,058,800.00
35420	Аж ахуйн материал	11,068,884.04	7,155,225.97
35440	Түлш, шатах тослох материал	2,440,000.00	1,800,000.00
35450	Барилгын засварын материал	3,803,410.00	5,392,850.00
35470	Бусад хангамжийн материал	138,816,836.37	172,884,586.37
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>740,779,719.20</u>	<u>648,171,142.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	740,779,719.20	648,171,142.88
392	Биет хөрөнгө	614,239,239.20	521,630,662.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	559,893,916.99	559,893,916.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(549,572,747.40)	(555,098,766.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,050,000.00	153,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,050,000.08)	(57,050,000.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,546,413,205.05	1,617,322,052.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,059,175,210.41)	(1,207,041,178.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,843,322.99	63,273,322.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(49,163,247.94)	(52,718,684.06)
393	Биет бус хөрөнгө	126,540,480.00	126,540,480.00
39301	Программ хангамж	1,182,500.00	1,182,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,182,500.00)	(1,182,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	126,540,480.00	126,540,480.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,498,571,757.73</u>	<u>1,541,876,530.55</u>

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,108,120.00</u>	<u>93,097,109.17</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,108,120.00	93,097,109.17
413	Өглөг	15,108,120.00	24,943,529.77
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	15,108,120.00	65,743,379.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,483,463,637.73</u>	<u>1,448,779,421.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,483,463,637.73	1,448,779,421.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,036,101,405.00	1,448,779,421.38
51101	Өмч: - төрийн	1,036,101,405.00	1,036,101,405.00
512	Хуримтлагдсан үр дүн	376,689,748.42	342,005,532.07
51210	Өмнөх үеийн үр дүн	180,048,991.64	376,689,748.42
51220	Тайлант үеийн үр дүн	196,640,756.78	(34,684,216.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,672,484.31	70,672,484.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,498,571,757.73</u>	<u>1,541,876,530.55</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,339,655,108.06	4,931,745,581.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	222,780,952.06	81,315,575.43
120	Нийтлэг татварын бус орлого	222,780,952.06	81,315,575.43
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	139,304,754.99	6,780,569.94
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	83,476,197.07	74,535,005.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,116,874,156.00	4,850,430,006.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,925,715,500.00	2,079,405,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,925,715,500.00	2,079,405,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,765,956.00	134,075,384.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,365,600.00	24,882,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,400,356.00	109,193,384.35
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	29,947,732.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	29,947,732.77
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,092,392,700.00	2,607,001,489.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,092,392,700.00	2,607,001,489.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,118,694,351.29	4,966,429,797.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,118,694,351.29	4,966,429,797.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,004,991,818.68	4,916,741,702.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,169,453,485.33	3,004,322,160.64
210101	Үндсэн цалин	1,230,516,696.65	1,515,663,164.19
210102	Нэмэгдэл	659,618,442.21	1,043,069,297.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	111,709,699.72	226,270,600
210104	Урамшуулал	167,608,646.75	217,389,340.00
210105	Гэрээт цалин	-	1,929,758.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267,569,677.96	363,950,149.85
210201	Тэтгэврийн даатгал	191,860,921.86	249,912,543.32
210202	Тэтгэмжийн даатгал	18,672,103.38	30,148,180.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,313,163.15	18,320,410.26
210204	Ажилгүйдлийн даатгал	3,782,007.60	12,892,873.72
210205	Эрүүл мэндийн даатгал	37,941,481.97	52,676,142.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,620,096.51	108,158,324.34
210301	Гэрэл, цахилгаан	31,472,844.45	30,990,658.67
210302	Түлш, халаалт	43,082,884.98	44,318,482.32
210303	Цэвэр, бохир ус	37,064,367.08	32,849,183.35
2104	Хангамж, бараа материалын зардал	88,679,445.95	84,092,939.92
210401	Бичиг хэрэг	5,750,130.00	8,492,810.00
210402	Тээвэр, шатахуун	12,640,000.00	10,640,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,772,383.50	13,418,161.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,194,000.00	14,460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,322,932.45	37,081,968.07
2105	Нормативд зардал	1,005,330,394.26	1,107,679,717.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	762,304,044.26	845,872,417.18
210502	Хоол, хүнс	243,026,350.00	261,807,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,185,060.00	47,060,132.00
210604	Урсгал засвар	21,185,060.00	47,060,132.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,359,893.62	30,525,917.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,116,974.00	11,890,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	3,000,000.000
210803	Даатгалын үйлчилгээ	698,629.62	2,634,703.71
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,952.00	234,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,509,000.00	12,485,000.00
210807	Газрын төлбөр	362,338.00	226,462.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,793,765.05	170,952,361.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,626,730.62	8,173,215.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	2,930,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	305,617,034.43	159,849,146.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,702,532.61	49,688,095.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,100,000.00	49,688,095.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж	-	44,388,095.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,100,000.00	5,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,602,532.61	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,602,532.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>220,960,756.77</u>	=
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,319,999.99	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	24,319,999.99	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(24,319,999.99)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>196,640,756.78</u>	<u>(34,684,216.35)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,846,588,056.00</u>	<u>4,744,553,161.48</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,846,588,056.00	4,744,553,161.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,925,715,500.00	2,079,405,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,925,715,500.00	2,079,405,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,765,956.00	130,975,384.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,365,600.00	21,782,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,400,356.00	109,193,384.35
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	29,947,732.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	29,947,732.77
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,822,106,600.00	2,504,224,644.36
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,822,106,600.00	2,504,224,644.36
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,785,195,389.47</u>	<u>4,657,391,638.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,785,195,389.47	4,657,391,638.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,671,492,856.86	4,607,703,543.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,197,725,885.90	3,053,021,313.30
210101	Үндсэн цалин	1,258,790,097.22	1,698,371,962.29
210102	Нэмэгдэл	659,617,442.21	1,003,410,760.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	111,709,699.72	142,121,489.26
210104	Урамшуулал	167,608,646.75	207,581,977.46
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,535,123.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,297,277.39	290,766,419.42
210201	Тэтгэврийн даатгал	163,588,521.29	190,568,773.51
210202	Тэтгэмжийн даатгал	18,672,103.38	25,936,788.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,313,163.15	11,535,363.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,782,007.60	9,843,415.15
210205	Эрүүл мэндийн даатгал	37,941,481.97	52,882,079.18

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,620,096.51	108,158,324.34
210301	Гэрэл, цахилгаан	31,472,844.45	30,990,658.67
210302	Түлш, халаалт	43,082,884.98	44,318,482.32
210303	Цэвэр, бохир ус	37,064,367.08	32,849,183.35
2104	Хангамж, бараа материалын зардал	81,138,703.50	91,545,121.85
210401	Бичиг хэрэг	4,378,650.00	8,056,860.00
210402	Тээвэр, шатахуун	13,500,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,772,383.50	13,418,161.85
210404	Ном хэвлэл	-	3,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,910,010.00	14,460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,577,660.00	11,199,790.00
210407	Аж ахуйн материал хулдан авах зардал	-	30,430,310.00
2105	Нормативд зардал	979,270,548.94	974,572,213.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	720,442,298.94	694,860,413.20
210502	Хоол, хүнс	243,026,350.00	261,807,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,801,900.00	17,904,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,590,850.00	48,145,722.00
210604	Урсгал засвар	23,590,850.00	48,145,722.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,282,264.00	30,391,214.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,616,974.00	11,890,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,952.00	234,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,054,000.00	12,485,000.00
210807	Газрын төлбөр	362,338.00	226,462.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	76,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,567,230.62	11,103,215.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,017,230.62	8,173,215.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	2,930,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,702,532.61	49,688,095.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	111,100,000.00	49,688,095.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		44,388,095.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,100,000.00	5,300,000.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,602,532.61	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,602,532.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	61,392,666.53	87,161,523.37
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	61,019,639.00	60,460,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,019,639.00	60,460,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	61,019,639.00	60,460,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	61,019,639.00	60,460,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(61,019,639.00)	(60,460,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	373,027.53	26,701,523.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	373,027.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	373,027.53	27,074,550.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,036,101,405.00	70,672,484.31	180,048,991.64	1,286,822,880.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,036,101,405.00	70,672,484.31	180,048,991.64	1,286,822,880.95
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	196,640,756.78	196,640,756.78
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,036,101,405.00	70,672,484.31	376,689,748.42	1,483,463,637.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,036,101,405.00	70,672,484.31	376,689,748.42	1,483,463,637.73
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,684,216.35)	(34,684,216.35)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,036,101,405.00	70,672,484.31	342,005,532.07	1,448,779,421.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	373,027.53	(373,027.53)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,389,005,400.00	4,556,928,520.99	832,076,879.01	84.56
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	5,389,005,400.00	4,556,928,520.99	832,076,879.01	84.56
210	Бараа, үйлчилгээний зардал	5,321,000,700.00	4,507,240,425.99	813,760,274.01	84.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,909,060,700.00	2,963,021,313.30	(53,960,613.30)	101.85
210101	Үндсэн цалин	1,343,874,100.00	1,608,371,962.29	(264,497,862.29)	119.68
210102	Нэмэгдэл	959,743,600.00	1,003,410,760.82	(43,667,160.82)	104.55
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	245,455,800.00	142,121,489.26	103,334,310.74	57.90
210104	Урамшуулал	359,987,200.00	207,581,977.46	152,405,222.54	57.66
210104	Гэрээт ажлын хөлс	-	1,535,123.47	(1,535,123.47)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	384,807,600.00	249,791,035.07	135,016,564.93	64.91
210201	Тэтгэврийн даатгал	257,470,100.00	149,593,389.16	107,876,710.84	58.10
210202	Тэтгэмжийн даатгал	30,290,500.00	25,936,788.01	4,353,711.99	85.63
210203	ҮОМШӨ ний даатгал	21,320,400.00	11,535,363.57	9,785,036.43	54.10
210204	Ажилгүйдлийн даатгал	15,145,400.00	9,843,415.15	5,301,984.85	64.99
210205	Эрүүл мэндийн даатгал	60,581,200.00	52,882,079.18	7,699,120.82	87.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,290,000.00	78,210,591.57	55,079,408.43	58.68
210301	Гэрэл цахилгаан	38,400,000.00	23,583,254.32	14,816,745.68	61.41
210302	Түлш, халаалт	50,750,000.00	33,856,866.51	16,893,133.49	66.71
210303	Цэвэр, бохир ус	44,140,000.00	20,770,470.74	23,369,529.26	47.06
2104	Хангамж, бараа материалын зардал	137,400,000.00	91,545,121.85	45,854,878.15	66.63
210401	Бичиг хэрэг	15,000,000.00	8,056,860.00	6,943,140.00	53.71
210402	Тээвэр (шатахуун)	30,000,000.00	10,000,000.00	20,000,000.00	33.33
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	21,600,000.00	13,418,161.85	8,181,838.15	62.12
210404	Ном, хэвлэлийн зардал	-	3,980,000.00	(3,980,000.00)	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,000,000.00	14,460,000.00	9,540,000.00	60.25

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	46,800,000.00	11,199,790.00	35,600,210.00	23.93
210407	Аж ахуйн материал хулдан авах зардал	-	30,430,310.00	(30,430,310.00)	
2105	Нормативт зардал	1,578,818,200.00	974,572,213.20	604,245,986.80	61.73
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,138,286,200.00	694,860,413.20	443,425,786.80	61.04
210502	Хоол, хүнс	420,000,000.00	261,807,300.00	158,192,700.00	62.34
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	20,532,000.00	17,904,500.00	2,627,500.00	87.20
2106	Эд хогшил худалдан авах	140,960,000.00	108,605,722.00	32,354,278.00	77.05
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000,000.00	59,030,000.00	20,970,000.00	73.79
210602	Тавилга	-	1,430,000.00	(1,430,000.00)	
210604	Урсгал засвар	60,960,000.00	48,145,722.00	12,814,278.00	78.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	17,150,000.00	30,391,214.00	(13,241,214.00)	177.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	11,890,000.00	(6,890,000.00)	237.80
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,500,000.00	3,000,000.00	500,000.00	85.71
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	2,500,000.00	(1,950,000.00)	454.55
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	234,752.00	(234,752.00)	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	55,000.00	145,000.00	27.50
210806	Мэдээллийн технологийн зардал	-	12,485,000.00	(12,485,000.00)	
210807	Газрын төлбөр	1,500,000.00	226,462.00	1,273,538.00	15.10
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,000,000.00	-	5,000,000.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,400,000.00	-	1,400,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,514,200.00	11,103,215.00	8,410,985.00	56.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,914,200.00	8,173,215.00	7,740,985.00	51.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,600,000.00	2,930,000.00	670,000.00	81.39

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,004,700.00	49,688,095.00	18,316,605.00	73.07
21320	Бусад урсгал шилжүүлэг	68,004,700.00	49,688,095.00	18,316,605.00	73.07
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	44,388,095.00	(44,388,095.00)	
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	68,004,700.00	5,300,000.00	62,704,700.00	7.79
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,389,005,400.00	4,583,630,044.36	805,375,355.64	85.06
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,079,405,400.00	2,079,405,400.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,079,405,400.00	2,079,405,400.00	-	100.00
134	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,309,600,000.00	2,504,224,644.36	805,375,355.64	75.67
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,309,600,000.00	2,504,224,644.36	805,375,355.64	75.67
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	373,027.53	(373,027.53)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	27,074,550.90	(27,074,550.90)	
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
	АЖИЛЛАГСДЫН ТОО	87	87	-	100.00
	Удирдах ажилтан	2	2	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	53	53	-	100.00
	Үйлчлэх ажилтан	32	32	-	100.00
	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙ Н ТОО	-	3,076	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлтүүд	Өмнөх он	Гүйцэтгэл
1	Нийт зарлага ба зээлийн дүн	98,765,956.00	160,923,117.12
21	Урсгал засвар	98,765,956.00	160,923,117.12
210	Бараа ажил үйлчилгээний зардал	-	160,923,117.12
210	Цалин хөлс нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	-	130,975,384.35
210101	Үндсэн цалин	-	90,000,000.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	-	40,975,384.35
2103	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ Зарцуулалт	-	29,947,732.77
210301	Гэрэл, цахилгаан	-	7,407,404.35
210302	Түлш, халаалт	-	10,461,615.81
210303	Цэвэр бохир ус	-	12,078,712.61
2105	Нормативт зардал	98,765,956.00	-
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,765,956.00	-
210502	Хоол, хүнс	20,000,000.00	-
2	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,765,956.00	160,923,117.12
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,365,600.00	21,782,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	89,400,356.00	109,193,384.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	29,947,732.77

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Энэрэл эмнэлэг нь “Хүнлэг энэрэнгүй ёсыг дээдэлсэн, чадварлаг менежменттэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, эрүүл мэндийн шинэлэг хандлагыг төлөвшүүлсэн хамт олон болно” гэсэн эрхэм зорилгын хүрээнд “Зорилтод бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үйлчлүүлэгчийнхээ сэтгэл ханамжийг дээдэлсэн, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг тав тухтай орчинд, тэгш хүртээмжтэй, тасралтгүй сайжруулан хүргэнэ” гэсэн чанарын бодлого баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Оношилгоо эмчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээг орчин үеийн нотолгоонд суурилсан олон улсын чанарын стандартад нийцүүлэн хүргэх,
- Эмнэлгийн мэргэжилтний тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах,
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлж, дадал хэвшил болгох ажлыг өрнүүлэх замаар амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй өвчлөл нас баралтыг бууруулах,
- Эмнэлгийн үйл ажиллагааг өргөжүүлэн орон гэргүй, ядуу эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Энэрэл эмнэлэг нь эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн тогтоолууд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн тухай журам;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 06 тоот тогтоол “Жагсаалт төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 14 тоот тогтоол “Жагсаалт төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай;
- Төрийн хэмнэлтийн хуулийн нэмэлт өөрчлөлт.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, дотоод хяналт хариуцсан ажилтныг 2024 оны 11-р сарын 11-ний өдөр томилсон байна. Дотоод хяналтын ажилтан нь

эмнэлгийн даргын 2024 оны А/10 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ийн дагуу хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх, хэм хэмжээ, хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанарын шалгуурыг хангаж буй эсэх, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, байгууллагын ил тод байдлын хяналт зэрэг чиглэлээр хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын газраас батлагдсан удирдамжийн дагуу 2023, 2024 оны санхүүгий үйл ажиллагаанд аудит хийхээр 2025 оны 02-р сарын 05-ны өдрөөс эхлэн ажлын 20 хоног ажиллаж байна. Иймээс 2024 оны санхүү, гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй харин дотоод аудитын хяналтын тайлан, үр дүнг дараагийн санхүүгийн жилийн аудитын үйл ажиллагаанд авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Энэрэл эмнэлгийн даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,304.8 мянга төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	373.0	27,074.5	26,701.5
Авлага	270,286.1	376,761.1	106,475.0
Урьдчилгаа	1,801.4	1,666.7	(134.7)
Бараа материал	485,331.5	488,203.1	2,871.6
Үндсэн хөрөнгө	740,779.7	648,171.1	(92,608.6)
Нийт хөрөнгө	1,498,571.7	1,541,876.5	43,304.8
Өр төлбөр	15,108.1	93,097.1	77,989.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,483,463.6	1,448,779.4	(34,684.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,498,571.7	1,541,876.5	43,304.8

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 27,074.5 мянган төгрөг болж өссөн нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг буцааж төвлөрүүлэхгүй болсонтой холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 376,761.1 мянган төгрөгт хүрч өсөхөд тайлант онд үүссэн эрүүл мэндийн даатгалын 373,062.9 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага голлон нөлөөлсөн байна. Нийслэлийн эрүүл мэндийн газраас орон гэргүй иргэдэд зориулсан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нь зориулж дээд шатны төсвийн байгууллагаас хуваарилсан төсвийн үлдэгдэл санхүүжилтаас үүссэн 3,100.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 488,203.1 мянган төгрөгийн 61.0 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдах эм боох материал, 34.0 хувийг бусад хангамжийн материал эзэлж байна. Хангамжийн материалын өсөлт нь эмнэлгийн гудас болон ор хөнжлийн даавуу, эмч сувилагчдын мэс заслын хослолыг шинээр сольсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь урсгал төсвийн худалдан авалтын 60,460.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,780.6 мянган төгрөгийн хөрөнгийн өсөлт, тайлант жилд байгуулсан элэгдэл 92,608.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлын бууралттай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 93,097.1 мянган төгрөгт хүрч өссөний 84.0 хувь нь эм боох материалын худалдан авалт, үлдсэн 26.0 хувь нь ажилчдын НДШ болон хувь хүний орлогын албан татварын өглөг байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт бүрэн орж ирээгүй нь өр төлбөрийн дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 34,684.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 3,309,600.0 мянган төгрөг, улсын төсвөөс 2,015,275.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 120,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 5,444,875.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Эмнэлгийн улсын төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 64,129.6 мянган төгрөгөөр өсгөж, 2,079,405.4 мянга төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,079,405.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,607,001.4 мянган төгрөг, нийт 4,686,406.8 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,079,405.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,504,224.6 мянган төгрөг, нийт 4,583,630.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,556,928.5 мянган төгрөг буюу 84.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 604,245.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлын төсвийг 55,079.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт/хувь/
1	Хүний хөгжлийн хөтөлбөр	2,559,778.00	1,772,968.76	786,809.24	69.3
2	Стратеги төлөвлөгөө ба үндсэн үйл ажиллагаа	2,829,227.40	2,783,959.76	45,267.64	98.4
	Дүн	5,389,005.40	4,556,928.52	832,076.88	84.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нийслэлийн эрүүл мэндийн газраас 21,782.0 мянган төгрөг, нийслэлийн төсвөөс орон нутгийн төсөвт байгууллагад олгох санхүүжилт 29,947.7 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 109,193.4 мянган төгрөг, нийт 160,923.1 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 130,975.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 29,947.7 мянган төгрөгийг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 2024 оны 01/326 тоот албан албан бичгээр Энэрэл эмнэлгийг 2024 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг эмнэлгийн бодит хэрэгцээнд үндэслэн төлөвлөж, төсөвт багтаан тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг мэдэгдсэн боловч мэргэшиж сургалтад хамрагдсан боловсон хүчний чадамжгүй гэсэн шалтгаанаар худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу хэрэгжүүлээгүй, зарим нэр төрлийн барааг ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авсан байна.

Төрийн худалдан авах газрын сонгон шалгаруулсан эрх бүхий байгууллагуудаас ерөнхий гэрээгээр эмнэлгийн тусламж үйлчилгээндээ зарцуулахаар 2024 онд 116 нэр төрлийн 331,234.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Энэрэл эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хөрөнгийн тооллогын үр дүнг тайлагнаж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоох, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон нотлох бусад баримтын бүрдлийг хангах, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын тооцооллын үнэн зөв байдлыг хянаж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, ур чадварын нэмэгдлийн шалгуур үзүүлэлт, ажлын үр дүнг үнэлэх, ажлаас гарсан ажилтнаас ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайлан, төсөв гүйцэтгэлийн тайлан, мэдээг хуулийн хугацаанд үнэн, зөв гаргаж ажиллах, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн тодорхойлох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид Юнити Аудит ХХК-ийн аудитор Д.Бадамцэцэг, аудиторын туслах Э.Цэнддорж, Г.Золзаяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын удирдлагын менежер Н.Тунгалаг, захирал Э.Мөнхтогтох, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар нар тус тус хэрэгжүүлсэн.

Энэрэл эмнэлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр албан тоот бичиггүй Солид Юнити Аудит ХХК-д ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 4,118,694.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 41,186.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь батлагдсан хөтөлбөр, төсвийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй, томилолтын зардал гаргаагүй, байр ашиглалттай холбоотой цахилгаан, дулаан, усны зардлыг өмнөх оноос нийт 3,461.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Энэрэл эмнэлэг нь 2024 онд нийт 4,712,500.1 мянган төгрөгийн 112 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 21 мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, 28 мэдээллийг ил тод байршуулаагүй байна. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 565,525.5 мянган төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 111,683.5 мянган төгрөгийн зарлагын 10 гүйлгээ, худалдан авалтын 35,136.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна. Мөн орлогын 167,119.2 мянган төгрөгийн 12 гүйлгээ, зарлагын 53,209.4 мянган төгрөгийн 4 гүйлгээ, худалдан авалтын 133,010.8 мянган төгрөгийн 12 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-т “Цалингийн зардлаас бусад таван мянга төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах зарим мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, байршуулаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд дээрх зөрчил давтагдан гарсан боловч байгууллагын удирдлага, нягтлан бодогчид солигдсон учраас албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг НЭМГ-аас албан бичгээр мэдэгдсэн боловч тайлант хугацаанд нийт 413,866.6 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-т "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна, худалдан авах ажиллагааг зохион байгуулна" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд дээрх зөрчил давтагдан гарсан боловч байгууллагын удирдлага, нягтлан бодогчид солигдсон учраас албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн зарим заалт, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, илрүүлсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 255,794.9 мянган төгрөгийн 9 залруулга, 2,911,934.19 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлснийг шалгахад алдааг бүрэн залруулж, 97,504.17 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжүүлээгүй асуудлуудыг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,274.6	1	4,274.6	100.0
Албан шаардлага	2	1,012,555.9	2	1,012,555.9	100.0
Зөвлөмж	2	492.6	1	492.6	50.0
Нийт дүн	5	1,017,323.1	4	1,017,323.1	83.0

Тайлант онд байгууллагын удирдлага, нягтлан бодогчид солигдсон тул дээрх хэрэгжээгүй зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалт хийгдсэн эсэх,
- Бараа материалын тооллого хийгдсэн эсэх,
- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дотоод аудитын хяналтын тайлангийн хэрэгжилтийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 602,923.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

- ЭМД санхүүжилтийн орлогыг 98,026.4 мянган төгрөгөөр бууруулж өөрийн үйл ажиллагааны орлогоор, НЭМГ-аас олгосон нэмэлт санхүүжилт 24,882.0 мянган төгрөгийг ангилал зөрүүлж бүртгэсэн;
- ЭМД-ын санхүүжилтийн 373,062.9 мянган төгрөгийн авлагыг ангилал зөрүүлж бүртгэсэн;
- ЭМД-ын санхүүжилт 85,170.1 мянган төгрөгийн орлого болон НЭМГ-ын нэмэлт санхүүжилт 21,782.0 мянган төгрөгийн орлогыг өөрийн үйл ажиллагааны орлогоор мөнгөн гүйлгээний тайланд ангилал зөрүүлэн толилуулсан.

Аудитаар нийт 1,222,755.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,937.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 527,969.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 692,847.9 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,222,755.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,181,568.3 мянган төгрөгөөр давсан тул “Сөрөг дүгнэлт” өглөө.

5.1 Төлбөрийн акт

Эмнэлгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 1,937.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгоход энэ журмын 2.1-д заасан “түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг илүү тооцож олгосон 1,937.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Төсвийн шууд захирагч нь ажлын туршлага, чадваргүй ажилтныг санхүү албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогчийн албан тушаалд томилсон, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь бэлтгэж тайлагнаагүй, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж архивлаагүй, хөрөнгө өр төлбөрийн тооллого, тооцоог хянаагүй, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, ажлын байрны тодорхойлолтод туссан чиг үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд цалин хөлсийг бүрэн олгосон, ажлаас чөлөөлөгдөх үед нь ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 8.9.1-т “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хүлээлцээгүй, баримтыг архивлаагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, хяналт тавьж ажиллаагүй удирдлагад сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант онд 10,640.0 мянган төгрөгийн шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох тооцооны хуудас, тооцоо бодсон зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох баримт хангалтгүй, хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Бараа материалын 488,203.1 мянган төгрөгийн үлдэгдэлд тайлант жилийн эцсээр тооллого хийгээгүй, эм боох материалын дэлгэрэнгүй тайлангийн эцсийн үлдэгдлийг нь санхүүгийн тайлангийн тодруулгын дүнгээс 2,220.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, эм боох материалын дэлгэрэнгүй тайлан нь зөрүүтэй зөрчлийг зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Тайлант оны өр төлбөрийн үлдэгдэл 24,641.8 мянган төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.5 Тайлант оны авлагын үлдэгдэл 598.1 мянган төгрөг, урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 1,666.7 мянган төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Авлага болон урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй 553,078.7 мянган төгрөгийн 11 барилга байгууламж, 33,050.0 мянган төгрөгийн 1 тээврийн хэрэгсэл, 753,169.0 мянган төгрөгийн 178 машин тоног төхөөрөмж, 29,304.1 мянган төгрөгийн 146 тавилга эд хогшил, 1,182.5 мянган төгрөгийн 4 программ хангамж бүртгэлтэй байна. Ашиглалтын хугацаа дуусаж, үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ", УСНББОУС -17 буюу үндсэн хөрөнгийн 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийг 307,708.0 мянган төгрөгөөр дутуу, гүйцэтгэлээрх зарцуулалтыг 182,021.4 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, 160,923.1 мянган төгрөгийн нэмэлт төсөв гүйцэтгэлийн тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн “54.4-т “Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна” 54.5.5-д Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, төсөв гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан, мэдээг иж бүрэн, үнэн зөвөөр хуулийн дагуу шаардлага хангасан хэлбэрээр цаг хугацаандаа бэлтгэж тайлагнах, түүний хэрэгжилтэд дээд шатны дотоод аудитын нэгж нь хяналт хийж, хэрэгжилтийн тайланг ирүүлэх

3. Анхан шатны баримтын бүрдэл, хяналттай холбоотой

Илрүүлэлт: Цаг бүртгэлийн системд зарим ажилчид цагаа бүртгүүлдэггүй, алба, тасгуудын цаг бүртгэл хариуцсан ажилтны бэлтгэсэн ажлын цагийн тооцоог холбогдох алба, тасгийн удирдлага болон тооцооны нягтлан бодогч, хүний нөөцийн менежер хянадаггүй, тухайн цагийн бүртгэл болон цалингийн тооцоог ахлах нягтлан бодогч, эмнэлгийн дарга хянаж баталгаажуулдаггүйгээс цагийн бүртгэл нь анхан шатны баримтаас зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ түүнийг нотлох анхан шатны баримтын үнэн зөв, иж бүрэн, хүчин төгөлдөр байдал болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

4. Ур чадварын нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдад 16,987.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтээр ажлын үр дүнг үнэлсэн нотлох баримтгүйгээр олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв” байх болон Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралт төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 2-д “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвх санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл олгоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг харгалзах шалгуур үзүүлэлтээр, ажлын үр дүнг үнэлэн, баримтаар баталгаажуулан олгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 12,295.4 мянган төгрөгийн тавилга үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотой анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ түүнийг нотлох анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, үнэн зөв нотлох баримтад үндэслэн бүртгэл хөтлөх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

6. Цалин хөлсний зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооны хүснэгтээс бүртгэлд тусгасан цалингийн зардал нь 7,986.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна. санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлыг бүртгэлд цалингийн тооцоолол түүнийг дэмжих анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв дүнгээр бүртгэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

7. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Эмнэлгийн ашиглалтын хугацаа дуусаж байгаа хөрөнгө болон ашиглах боломжгүй актлах хөрөнгийн талаар хэлэлцэж, арга хэмжээ авч ажиллаагүй, хөрөнгийн тооллогын үр дүнг нэгтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогоор хөрөнгийн ашиглалт, чанар байдал болон бодитой оршин буй эсэхийг тогтоон, үр дүнг нэгтгэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

8. Бараа материалын норм нормативтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтаар эмийн нөөц нийт 545 нэр төрлийн эм байхаас эмнэлгийн нөөцөд 443 нэр төрөл буюу 81.2 хувийн 7-21 хоног ашиглах нөөцтэй байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл, тоо хэмжээнд дүн шинжилгээ хийхэд 1,000 ширхгээс дээш тоо хэмжээтэй 18,106 ширхэг 8 нэр төрлийн эм байгаа бөгөөд нийт 102 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нөөцөд байхгүй зэрэг зарим эмийн нөөц маш их, зарим эмийг нөөцлөөгүй байгаа нь зайлшгүй байх нөөцийн хэмжээг бодит нөхцөл байдал шаардлагад нийцүүлэн тодорхойлоогүй байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/197 тушаалын 1 дүгээр хавсралтаар “зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг хэрэгжүүлж ажиллах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны дотоод аудитын нэгж хяналт хийж, хэрэгжилтийн тайланг ирүүлэх.

9. Хувь хүний орлогын албан татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын тайланд ажилчдаас суутгасан эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг 4,479.6 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, 447.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх", Татварын ерөнхий хуулийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварыг тайланд тусгах мэдээллийг нийгмийн даатгалын тайлангийн дүнтэй тулган шалгаж, үнэн зөв тайлагнах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн орлого, үндсэн үйл ажиллагааны орлого, Нэмэлт санхүүжилтийн орлогыг ангилал зөрүүлэн толилуулсан.	1	122,908.4	-	-	1	122,908.4	1	122,908.4	-	-	-	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг бусад авлагаар ангилал зөрүүлэн толилуулсан.	1	373,062.9	-	-	1	373,062.9	1	373,062.9	-	-	-	-
НЭМГ-с орон гэргүй иргэдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ зориулан олгосон санхүүжилтийг өөрийн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	1	106,952.1	-	-	1	106,952.1	1	106,952.1	-	-	-	-
Дүн	3	602,923.4	-	-	3	602,923.4	3	602,923.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хөрөнгийн тооллогын үр дүнг нэгтгэж, тайлагнаагүй. Ашиглалтын хугацаа дуусаж байгаа болон актлах хөрөнгөнд арга хэмжээ авч ажиллаагүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тавилга, тоног төхөөрөмжийг анхан шатны баримтгүй бүртгэсэн.	1	12,295.40	-	-	-	-	-	1	12,295.40	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Цалингийн тооцооны хүснэгтээс бүртгэлд тусгасан цалингийн зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	7,986.20	-	-	-	-	-	1	7,986.20	-	-	-	-
Суутган татварын тайланд даатгуулагчийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг зөрүүтэй тайлгаснаас ХХОАТ-ыг дутуу тайлагнасан.	1	4,926.60	-	-	-	-	-	1	4,926.60	-	-	-	-

Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цаг бүртгэлийн системд цагаа бүрэн бүртгүүлдэггүй, ажлын цагийн тооцоог холбогдох албан тушаалтнууд хянаж баталгаажуулдаггүй, цагийн бүртгэл нь анхан шатны баримтаас зөрүүтэй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	1,937.60	1	1,937.6	-	-	-	-	-	-	-	-	-
Ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур үзүүлэлтээр ажлын үр дүнг үнэлсэн нотлох баримтгүйгээр олгосон.	1	16,987.2	-	-	-	-	1	16,987.2	-	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл зөрүүтэй, нэмэлт төсөв гүйцэтгэлийн тайлан бэлтгээгүй.	1	650,652.5	-	-	-	-	1	650,652.5	-	-	-	-	-
Тайлант 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр авлага, урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	2,264.8	-	-	1	2,264.8	-	-	-	-	-	-	-

Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	24,641.80	-	-	1	24,641.8	-	-	-	-	-	-
Бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй. Эм боох материалын дэлгэрэнгүй тайлангийн эцсийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн тодруулгын дүнгээс зөрүүтэй.	1	490,423.10	-	-	1	490,423.1	-	-	-	-	-	-
Шатахууныг дараа тооцоогоор бүртгэдэггүй зарцуулалтыг нотлох баримтууд дутуу, хяналт тавьж баталгаажуулаагүй	1	10,640.00	-	-	1	10,640.0	-	-	-	-	-	-
Ажлын туршлага, чадваргүй ажилтныг томилсон, санхүүгийн тайланг хугацаанд нь тайлагнаагүй, чиг үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд цалин хөлсийг бүрэн олгосон, хяналт тавьж ажиллаагүй	1	-	-	-	-	-	-	-	1	1	-	-
Зайлшгүй шаардлагатай нөөцөд зарим эм, эмнэлгийн хэрэгсэл байхгүй, зарим нь маш их, нөөцлөх тоо хэмжээг тодорхойлсон баримтгүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	15	1,222,755.2	1	1,937.6	4	527,969.7	9	692,847.9	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хуулийн дагуу 28 мэдээллийг ил тод байршуулаагүй, 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	1,065,685.3	-	-	1	1,065,685.3	-	-
Дүн	1	1,065,685.3	-	-	1	1,065,685.3	-	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой								
Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах тендерийг цахимаар зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.	1	413,866.6	-	-	1	413,866.6	-	-
Дүн	1	413,866.6	-	-	1	413,866.6	-	-
Нийт дүн	2	1,479,551.9	-	-	2	1,479,551.9	-	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 56/17810549

Улаанбаатар хот

НТАГ-2025/150/ИА-СТА-Тулз

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмнэлгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 1,937,600.00 (нэг сая есөн зуун гучин долоон мянга зургаан зуун) төгрөгөөр илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгоход энэ журмын 2.1-д заасан "түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн," заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг илүү тооцож олгосон 1,937,600.00 (нэг сая есөн зуун гучин долоон мянга зургаан зуун) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.МӨНХТОГТОХ

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 208/17810549

Улаанбаатар хот

НТАГ - 2025/150/ММ - СТН - ТШБ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын туршлага, чадваргүй ажилтныг Санхүү албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогчийн албан тушаалд томилсон, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь бэлтгэж тайлагнаагүй, санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж архивлаагүй, хөрөнгө өр төлбөрийн тооллого, тооцоог хянаагүй, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж бүрэн баталгаажуулаагүй, ажлын тодорхойлолтод тусгасан чиг үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд цалин хөлсийг бүрэн олгосон, ажлаас чөлөөлөгдөх үед нь ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төрийн аудитын байгууллагад тогтоосон хугацаанд шаардсан баримт мэдээллийг бүрэн ирүүлээгүй, аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх үүргээ биелүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг гаргасан Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл

02043480

дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга (Х.Бат-Ирээдүй)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.МӨНХТОГТОХ

Я.АЛТАНЦЭЦЭГ



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 209/17810549

Улаанбаатар хот

ИТАГ - 2025 / 150 / МЭ - СТМ - ТМШ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 10,640,000.00 (арван сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийн шатахууныг бараа материалаас шаардах хуудсыг үндэслэн талноор олгодог боловч дараа тооцоогоор бүртгэдэггүй зарцуулалтыг нотлох тооцооны хуудас, тооцоо бодсон зарцуулалтын баримтууд дутуу, зарцуулалтад хяналт тавьж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууныг дараа тооцоогоор бүртгээгүй, зарцуулалтыг нотлох баримтууд хангалтгүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх төрийн аудитын газар -т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 22/17810549

Улаанбаатар хот

ИТАГ - 2025/150/УА - СМА - ТИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны авлагын үлдэгдэл 598,102.00 (таван зуун ерэн найман мянга нэг зуун хоёр) төгрөг, урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 1,666,666.67 (нэг сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага болон урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 01 сарын 25 өдөр

Дугаар АИР/17810549

Улаанбаатар хот

ИТАС - 2025 / (СБ/МА-СТМ - ТМ)

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны өглөгийн үлдэгдэл 24,641,858.08 (хорин дөрвөн сая зургаан зуун дөчин нэгэн мянга найман зуун тавин найман төгрөг найман мөнгө) төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 840/17810549

Улаанбаатар хот

НПАГ - 2025/150/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын 488,203,069.46 (дөрвөн зуун наян найман сая хоёр зуун гурван мянга жаран есөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийг үлдэгдэлд тайлант жилийн эцсээр тооллого хийгээгүй, эм боох материалын дэлгэрэнгүй тайлангийн эцсийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн тодруулгын дүнгээс 2,220,054.00 (хоёр сая хоёр зуун хорин мянга тавин дөрвөн) төгрөгөөр илүү бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-т "үнэн зөв байх" 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, эм боох материалын дэлгэрэнгүй тайлан нь зөрүүтэй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны дотор Нийслэл дэх төрийн аудитын газар -т ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ





НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 013/17810549

Улаанбаатар хот

ИТАГ - 2025/150/НА - СТ - 213

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд эм эмнэлгийн хэрэгслийн 413,866,606.89 (дөрвөн зуун арван гурван сая найман зуун жаран зургаан мянга зургаан зуун зургаан төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна худалдан авах ажиллагааг зохион байгуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тендер шалгаруулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.МӨНХТОГТОХ

ХЯНАСАН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 214/17810549

Улаанбаатар хот

ИТАС-2025/ISO/WA-CTA-TMS

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Энэрэл эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 565,525,538.03 (таван зуун жаран таван сая таван зуун хорин таван мянга таван зуун гучин найман төгрөг гурван мөнгө) төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 111,683,500.00 (нэг зуун арван нэгэн сая зургаан зуун наян гурван мянга таван зуун) төгрөгийн зарлагын 10 гүйлгээ, худалдан авалтын 35,136,900.00 (гучин таван сая нэг зуун гучин зургаан мянган есөн зуун) төгрөгийн 2 гүйлгээг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 167,119,200.00 (нэг зуун жаран долоон сая нэг зуун арван есөн мянга хоёр зуун) төгрөгийн 12 гүйлгээ, зарлагын 53,209,390.81 (тавин гурван сая хоёр зуун есөн мянга гурван зуун ерэн төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн 4 гүйлгээ, худалдан авалтын 133,010,820.00 (нэг зуун гучин гурван сая арван мянга найман зуун хорь) төгрөгийн 12 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван мянга төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроон мэдээлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэ;

2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Энэрэл эмнэлгийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч А.Сувдаа, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

Э.МӨНХТОГТОХ

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040235